


“Бэрс финанс ББСБ” ХХК-ийн ТУЗ-ийн 2023 оны 01-р сарын
04-ний өдрийн 23/01а/01 тоот тогтоолын Хавсралт 12”



ШҮГЭЛ ҮЛЭЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү журмаар компанийн хэмжээнд шүгэл үлээх бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааг зохицуулна.
- 1.2 “Шүгэл үлээх үйл ажиллагаа” гэж компанийн болон харилцагчид, ажилтан албан хаагчдын нийтлэг ашиг сонирхлыг хохироосон, хохироож болзошгүй нөхцөл байдал, үйлдлийн талаар эрх бүхий этгээдэд мэдээлэл өгөх, гомдол гаргах, тайлбар өгөх үйл ажиллагааг ойлгоно.

Хоёр. Шүгэл үлээх нөхцөлийг бүрдүүлэх

- 2.1 Компанийн хэмжээнд шүгэл үлээх мэдээллийг хүлээн авах эрхтэй этгээд нь гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн дарга, ТУЗ-ийн Аудитын хорооны дарга, дотоод аудитын баг байна.
- 2.2 Эдгээр хүмүүст мэдээлэл өгөхдөө бичгээр, биечлэн уулзаж болон утсаар мэдээлэл өгөх боломжтой байна.
- 2.3 Эдгээр хүмүүсийн “гарт нь” гэсэн дугтуйтай бичгийг бусад ажилтнууд нээж үзэх эрхгүй байна.
- 2.4 Эдгээр хүмүүст утсаар мэдээлэл өгөх боломжийг бүрдүүлэхийн тулд утасны дугаарыг нь нийгэд нээлттэй хэлбэрээр байршуулах үүргийг ТУЗ-ийн нарийгн бичгийн дарга хүлээнэ.

Гурав. Шүгэл үлээх ажиллагааг хэрэгжүүлэх

- 3.1 Шүгэл үлээхийг хүссэн этгээд нь мэдээллийг хэнд хүргэх, ямар хэлбэрээр хүргэх, өөрийн нэрийг нууцлах эсэхээ өөрөөр шийднэ.
- 3.2 Шүгэл үлээхийг хүссэн этгээд нь өгөх мэдээллээ сонгосон этгээддээ сонгосон хэлбэрээр хүргэнэ.
- 3.3 Шүгэл үлээх журмаар хүргэсэн мэдээллийг хүлээн авсан этгээд нь уг мэдээлэлтэй танилцаад дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:
 - 3.3.1 Шүгэл үлээх журмаар хүлээн авсан мэдээллийн мөрөөр шалгалт хийх эсэх, шалгалт хийх бол ямар хэлбэрээр шалгалт хийхээ шийдвэрлэнэ.
 - 3.3.2 Ямар шалгалт хийхээ шийдвэрлэсний дараа шалгалтын ажлын хэсгийг томилж, удирдамжийг батална.

- 3.3.3 Шалгалт дуусаж, дүгнэлтийг хүлээн авсны дараа ямар арга хэмжээ авахаа шийдвэрлэнэ.
- 3.3.4 Шалгалт хийлгүй асуудлыг шийдвэрлэх боломжтой гэж үзсэн тохиолдолд холбогдох арга хэмжээг авч шүгэл үлээгчид хариу мэдэгдэнэ.
- 3.3.5 Шалгалтын мөрөөр арга хэмжээ авсан тохиолдолд асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн талаар шүгэл үлээгчид хариу мэдэгдэнэ.

Дөрөв. Шүгэл үлээсэн мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ

- 4.1 Шүгэл үлээх журмаар авсан мэдээллийн мөрөөр авах арга хэмжээ нь хүлээж авсан мэдээлэл хэр зэрэг ноцтой мэдээлэл байснаас шалтгаална.
- 4.2 Шүгэл үлээх журмаар хүлээн авсан мэдээлэл нь нотцой гэмт хэргийн чанартай үйлдлийн талаарх мэдээлэл байсан тохиолдолд хуулийн байгууллагад шилжүүлэн шалгуулах арга хэмжээ авна.
- 4.3 Компани дотроо шийдвэрлэх боломжтой асуудлын талаарх мэдээлэл байсан тохиолдолд энэ журмын 3.3.3-т заасны дагуу дүгнэлтийг хүлээн авсны дараа холбогдох арга хэмжээ авна. Үүнд:
 - 4.3.1 Гүйцэтгэх захирал тушаал шийдвэр гаргах замаар асуудлыг шийдвэрлэх
 - 4.3.2 ТУЗ-ийн хурлаар асуудлыг хэлэлцүүлэн шийдвэрлэх
 - 4.3.3 Холбогдох буруутай этгээдэд шийтгэл ногдуулж учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх замаар шийдвэрлэх
 - 4.3.4 Холбогдох дүрэм журамд нэмэлт өөрчлөлт оруулах замаар шийдвэрлэх
 - 4.3.5 Бусад холбогдох арга хэмжээ авах
- 4.4 Шүгэл үлээгч өгсөн мэдээллийн мөрөөр ямар нэг арга хэмжээ аваагүй тохиолдолд шүгэл үлээгч мэдээллээ дээд шатны албан тушаалтанд, эсхүл хянах зохицуулах эрх бүхий байгууллагад мэдээлэл өгөх эрхтэй байна.

Тав. Хариуцлага

- 5.1 Энэ журмыг зөрчиж шүгэл үлээх замаар хүлээн авсан мэдээллийн мөрөөр арга хэмжээ аваагүй, шүгэл үлээгч мэдээллээ нууцлахыг хүссэн тохиолдолд түүний нууцлахыг хүссэн мэдээлэл тухайлбал, шүгэл үлээгчийн хувийн мэдээллийг задалсан зэргээр энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд ажлаас нь чөлөөлөх хүртэл арга хэмжээ авна.